**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2025 оны 05 сарын 16 өдөр Дугаар А/15 Арвайхээр сум

Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийх, “Хаалганаас-хаалганд” үзлэг шинжилгээг зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай” А/528, “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” А/609, Эрүүл мэндийн сайдын 2024 оны “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай” А/38 дугаар тушаалууд болон “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сумын Эрүүл мэндийн төвийн түвшинд бэхжүүлэх” дэд хөтөлбөр (MNG-C-MON 3282)-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1.“Хаалганаас-хаалганд” үзлэг, шинжилгээг зохион байгуулах болон сумдын эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил, арга зүйгээр хангах багуудын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын чиг үүргийг хоёрдугаар, сумдад ажиллах хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх 2 багтай сумдад хамтран ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг томилон, шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, автомашины дэмжлэг үзүүлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Г.Дашжанцан), Хархорин сумын нэгдсэн эмнэлэг (Д.Энхзаяа) болон сумдын эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Эрүүл мэндийн цогц үзлэгт зарцуулагдах зардлыг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (Б.Валя), сумдын эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4.Үзлэг, дэмжлэгт хяналтыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАЯР

622301056

My Doc.tushaal/EMG/

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 05 сарын 16-ны өдрийн
А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

"ХААЛГАНААС-ХААЛГАНД" ҮЗЛЭГ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| Д/д | Багийн бүрэлдэхүүн | Овог нэр | Ажлын газар, албан тушаал | Холбоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Бусийн оношилгоо эмчилгээний төв | Б.Даваамаа | БОЭТ-ийн Сүрьеэгийн диспансерийн эмч | 88103303 |
| 2. | | У.Мөнгөнсүх<br>Ц.Лхагвадаш | БОЭТ-ийн рентген техникч | 99929234<br>99937307 |
| 3. | | Т.Дашдорж | БОЭТ-ийн жолооч | 99324235 |
| 4. | Баруунбаян-Улаан | Ш.Пүрэвхорлоо | Их эмч | 86141221 |
| 5. | | Б.Хоролнямбуу | Лаборант | 95571281 |
| 6. | | Ш.Баасансүрэн | Жолооч | 99336436 |
| 7. | Бат-Өлзий | Б.Уянга | Их эмч | 85359324 |
| 8. | | М.Отгонцэцэг | Лаборант | 99150843 |
| 9. | | Р.Цэрэнчимэд | Жолооч | 95760337 |
| 10. | Баян-Өндөр | Б.Дашдэлгэр | Их эмч | 99320988 |
| 11. | | Б.Сувд-Эрдэнэ | Лаборант | 88651909 |
| 12. | | С.Ганхуяг | Жолооч | 88895051 |
| 13. | Бүрд | Б.Золжаргал | Их эмч | 99829183 |
| 14. | | Н.Энхтөр | Лаборант | 99921639 |
| 15. | | Д.Бүтэд-Очир | Жолооч | 99016597 |
| 16. | Богд | Ц.Бямбасүрэн | Их эмч | 99326619 |
| 17. | | П.Тогосмаа | Лаборант | 95684120 |
| 18. | | Ж.Ганболд | Жолооч | 91881159 |
| 19. | Зүүнбаян-Улаан | Б.Нандин-Эрдэнэ | Их эмч | 90115289 |
| 20. | | Ц.Чимгээ | Лаборант | 94444239 |
| 21. | | Ц.Тэгшдорж | Жолооч | 95329625 |
| 22. | Сант | Б.Соёлмаа | Их эмч | 89994948 |
| 23. | | Ц.Хишигтогтох | Лаборант | 88852192 |
| 24. | | Ц.Пүрэвдорж | Жолооч | 89191512 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 25. | Нарийнтээл | Б.Мөнхзул | Их эмч | 88809786 |
| 26. | | Н.Одгэрэл | Лаборант | 88354046 |
| 27. | | Б.Ганбаатар | Жолооч | 99765997 |
| 28. | Уянга | Б.Сосорбурам | Их эмч | 99488154 |
| 29. | | Б.Дуламсүрэн | Лаборант | 99620307 |
| 30. | | А.Давгадорж | Жолооч | 99323849 |
| 31. | Хайрхандулаан | Б.Өлзийхишиг | Их эмч | 90383888 |
| 32. | | Д.Түвшинжаргал | Лаборант | 95788686 |
| 33. | | С.Тогоосүрэн | Жолооч | 99328528 |
| 34. | Хархорин | Э.Амаржаргал | Их эмч | 86022141 |
| 35. | | Л.Баясгалан | Лаборант | 99020067 |
| 36. | | Д.Эрдэнэхүү | Жолооч | |
| 37. | Хужирт | Б.Азжаргал | Их эмч | 88282913 |
| 38. | | Ё.Ганчимэг | Лаборант | 88760469 |
| 39. | | З.Батсайхан | Жолооч | 80603678 |

## “ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ” ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| Д/д | Багийн бүрэлдэхүүн | Овог нэр | Ажлын газар, албан тушаал | Холбоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | ЭМГ, БОЭТ, Сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо | Я.Жаргал | ЭМГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга | 89191996 |
| 2. | | С.Долгормаа | ЭМГ-ын НЭМХ-ийн халдварт өвчин, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн | 99811568 |
| 3. | | Б.Дашдэлгэр | Баян-Өндөр сумын ЭМТ-ийн дарга, МСЭМХ-ны Өвөрхангай аймаг дахь салбарын дарга | 99320988 |
| 4. | | П.Сундуйбанзрагч | ЭМГ-ын жолооч | 99327550 |

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
А/15 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

"ХААЛГАНААС ХААЛГАНД" ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ
ХИЙХ БАГИЙН ЧИГ ҮҮРЭГ

**Нэг. Эрүүл мэндийн газрын чиг үүрэг:**

1.Эрсдэлт бүлгийн хүн амыг үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах;

2.Идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн багт ажиллах Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сүрьеэгийн эмч, рентген техникч, сумдын эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, лаборант болон жолооч нарыг тухайн эрүүл мэндийн байгууллагын дарга нартай харилцан зөвшилцөж, томилуулан ажиллуулах;

3.Идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн багийн гишүүдэд цахим сургалтыг зохион байгуулж, ажлын чиг үүргийг танилцуулж, арга зүйгээр хангах;

4.Үзлэгт хамрагдах /сум, баг/-ийн зураглалыг гаргаж, үзлэг хийх айл өрх, хүний тоог сумдаас урьдчилан авч, нэгдсэн судалгаа гаргасан байх;

5.Үзлэг хийх багт дэмжлэг үзүүлж, сумдын бэлэн байдлыг хангуулж, явцын хяналт хийх;

6.Үзлэгийн багийн сумдад ажиллах шатахууны болон орон нутагт ажилласан томилолтын зардлыг Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос хуваарилсны дагуу олгох ажлыг зохион байгуулах;

7.МСЭМХ-оос сумдад олгогдсон шатахууны зарцуулалтын замын хуудас, томилолтын зардал зэрэг санхүүгийн баримтыг бүрдүүлэх;

8.Үзлэгийн тайлан, мэдээг хянаж, МСЭМХ-нд заасан хугацаанд хүргүүлэх;

**Хоёр. Бүсийн оношилгоо эмчилгээний чиг үүрэг:**

1.Идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн багийн гишүүдийг томилж, зөөврийн рентген аппарат болон бусад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангаж хамтран ажиллах;

2.Үзлэгийн явцад сумдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, сүрьеэгийн мэргэжсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

3.Илэрсэн тохиолдлын эмчилгээ, хяналтын асуудлыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар батлагдсан "Сүрьеэгийн тусламж үйлчилгээний үзүүлэх журам, заавар"-ыг баримтлан хэрэгжүүлэх;

4.Идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн үед иргэдээс цэрний сорьцыг бүрэн авч

сүрьеэгийн лабораторид илгээх, мэргэжил арга зүйгээр хангах;

5.Сорьцод молекул биологийн түргэвчилсэн шинжилгээ /түрхцийн/-г хийж, хариуг үзлэгийн багт эргэн мэдээлж, хүргүүлэх;

6.Нян судлалаар батлагдсан тохиолдлыг бүртгэлд авч, эмчилгээнд хамруулах ажлыг холбогдох журам, аргачлалын дагуу зохион байгуулах;

7.ХӨСҮТ-ийн захирлын баталсан “Хаалганаас хаалганд” идэвхтэй илрүүлэлт зохион байгуулах үйл ажиллагаа, Эрүүл мэндийн газрын даргын тушаалын аргачлалыг мөрдлөг болгон, үзлэгийн хугацаанд нийт үзлэг, шинжилгээний мэдээг асуумж болон цээжний рентген шинжилгээнд өөрчлөлттэй боловч нян судлалаар батлагдаагүй тохиолдлыг эмнэлзүйн хурлаар хэлэлцүүлж, нэмэлт оношилгоо хийх, эмнэлзүйгээр эмчилгээнд орох шаардлагатай тохиолдлыг тодорхойлон ажиллах;

8.Сумдаас тайлан мэдээг тухайн өдөрт нь гаргуулан авч явах;

**Гурав. Сумын эрүүл мэндийн төвийн чиг үүрэг:**

1.Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн ялангуяа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэнд “Хаалганаас-хаалганд” хүрч үйлчлэх, нэг ч хүнийг орхигдуулахгүйгээр хамруулах ажлыг зохион байгуулах, бэлтгэлийг хангах;

2.Нийт эрсдэлт бүлгийн судалгаанаас өндөр эрсдэлтэй хүний тоог оруулан үзлэгт хамрагдах хүмүүсийн мэдээллийг Эрүүл мэндийн газарт урьдчилан хүргүүлж, судалгааны дагуу хүн амыг үзлэгт бүрэн хамруулах;

3.Идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн багт сумын эрүүл мэндийн төвөөс хамтарч ажиллах, эмч, мэргэжилтнүүдийг томилон бүртгэл, асуумж ярилцлагын хэсэгт ажиллах эмч, сувилагч, цэрний сорьц цуглуулах, тээвэрлэн хүргэх лаборант, жолооч нарыг тус тус албажуулсан байх;

4.Сумын эрүүл мэндийн төвийн жолооч нь айл өрхөөс үзлэгт хамрагдах зорилтот бүлгийн иргэдийг үзлэгийн байранд авчрах, буцааж хүргэх, сорьц тээвэрлэх ажлыг эрүүл мэндийн төвийн даргын өгсөн чиг үүргийн дагуу гүйцэтгэх;

5.Хархорин сумын нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төвөөс үзлэгийн багт ажиллах эмч, мэргэжилтнүүд нь Эрүүл мэндийн газраас зохион байгуулах сургалтад бүрэн хамрагдсан байх;

6.Үзлэг зохион байгуулах ажлын байрыг сонгож, халдварын сэргийлэлт, хяналтын журмыг баримтлан бэлтгэсэн байх;

7.Идэвхтэй илрүүлэлт зохион байгуулах товыг гарган, үзлэг эхлэхээс 3-5 хоногийн өмнө маягт 1- д бүртгэгдсэн хүн амд зар хүргэсэн байх, үзлэгт бүрэн хамруулах арга хэмжээг зохион байгуулсан байх;

8.Орон нутгийн удирдлагын оролцоог ханган багийн Засаг дарга, нийгмийн ажилтан болон Олон нийтийн эрүүл мэндийн ажилтныг татан оролцуулах замаар зохион байгуулах;

9.Үзлэгийн багийн эмч, мэргэжилтнүүдийг сум, багт ажиллах хугацаанд байр, хоол болон шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, сорьц цуглуулах сав, сорьц тусгаарлах түгжээтэй уут, термометр, аюулгүй хайрцаг, сорьц тээвэрлэх мөсөн элемент бүхий сав, халдварын сэргийлэлт болох нэг удаагийн халад, бээлий, амны хаалт, гар ариутгагч, бусад шаардлагатай зүйлсээр бүрэн хангах;

10.Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээний асуумжийг Google form-: https://forms.gle/3s5CHWeEDTSDTzJu6 нэвтрэн орж, хүн тус бүрээр авах;

11.Үзлэгийн сүрьеэтэй байж болзошгүй гарсан тохиолдлын сорьцыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх ажлыг холбогдох журмын дагуу сүрьеэгийн лабораторид илгээж хариуг авах, үзлэгийн багийн эмчид танилцуулах;

12.Үзлэгт хамрагдагсдад сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэлтийн ач холбогдлын талаар мэдээлэл, сурталчилгаа хийж, зөвлөгөө өгөх;

13.Идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг үзлэг дууссанаас хойш ажлын 2 хоногт багтаан Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс ажилласан багийн ахлагчид хүргүүлэх;

**Дөрөв."Хаалганаас хаалганд" үзлэгийн хамтарсан багийн чиг үүрэг:**

1.Аймгийн Эрүүл мэндийн газраас гаргасан сум, багийн зураглал, сумдад ажиллах хуваарийн дагуу эрсдэлт бүлгээс сонгогдсон хүн амыг үзлэгт бүрэн хамруулах

2.Судалгааны дагуу үзлэгт хамрагдаж буй иргэдээс асуумж авч, цээжний рентген шинжилгээнд хамруулах;

3.Сүрьеэ илрүүлэх үзлэг, шинжилгээний асуумжийг Google form: https://forms.gle/3s5CHWeEDTSDTzJu6 нэвтрэн орж хүн тус бүрээр авах;

4.Асуумж, рентген шинжилгээгээр сүрьеэтэй байж болзошгүй гарсан иргэнд цэр өгөхийн учир шалтгааныг сайтар тайлбарлан, зөвлөмж өгч цэрний сорьц цуглуулах;

5.Үзлэгээр сүрьеэтэй бүртгэгдсэн тохиолдолд шинжилгээний дүнг эргэн танилцуулах хугацаа, байршил зэргийг тохирох;

6.Үзлэгийн багийн ахлагч нь идэвхтэй илрүүлэлтийн үзлэгийн үйл ажиллагааны болон санхүүгийн бичмэл, тоон тайланг баримтжуулалтын хамт үзлэг дууссанаас хойш ажлын 2 хоногт сумдын эрүүл мэндийн тайлантай нэгтгэн, Эрүүл мэндийн газарт хүргүүлэх;

**Тав. Дэмжлэгт хяналт хийх баг, хамтарч ажиллах сумдын эмч, мэргэжилтнүүдийн чиг үүрэг**

1.Сумдын эрүүл мэндийн төвүүд нь 2024 онд хийгдсэн дэмжлэгт хяналтын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг гаргаж бэлтгэсэн байх

2.Дэмжлэгт хяналтын багтай хамтран ажиллах сүрьеэгийн асуудал хариуцсан эмч, мэргэжилтэн нь тухайн суманд ажиллах өдөр ажлын байрандаа бэлэн байх

3.Холбогдох анхан шатны бүртгэл маягт, судалгааг бэлтгэсэн байх

4.Дэмжлэгт хяналтын баг нь “Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний дэмжлэгт хяналтын хуудас”-т тусгагдсан асуумжийн дагуу үнэлгээг хийх;

5.Үнэлгээг хийхдээ сумын эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлыг үнэлж, үнэлгээнд тулгуурлан цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтэд байнгын хяналт тавих;

6.Сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд 2024 онд хийсэн дэмжлэгт хяналтын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлантай танилцаж, үр дүнг нягтлах, мэдээ гаргалтын байдлыг газар дээр нь хянан, зөвлөмж өгч, бэрхшээл хүндрэлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

7.Дэмжлэгт хяналтад хамрагдсан биечлэн болон цахимаар хамрагдсан сумдын эрүүл мэндийн төвд шаардлагатай зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин, эргэх холбоотой ажиллах;

8.Дэмжлэгт хяналтын үйл ажиллагааны тайланг, "Сүрьеэгийн тусламж үйлчилгээний дэмжлэгт хяналтын хуудас"-ыг сумын эрүүл мэндийн төв тус бүрээр гаргаж, нэгтгэн, үр дүнг Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоонд хагас жилээр 06 дугаар сарын 10, бүтэн жилээр 12 дугаар сарын 10-ны дотор эргэн тайлагнах;

9.Санхүүгийн бүртгэлийн журмын дагуу анхан шатны маягтыг үнэн зөв хөтөлж, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоонд 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор тайланг хүргүүлэх;

---oOo---

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
А/15 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

## ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ТОО, ХУВААРЬ

| № | | Сумын нэр | Нийт эрсдэлт бүлгийн тоо | Хаалганаас хаалганд үзлэгт хамрагдах тоо | Ажил-лах хоног | Хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1-р маршрут | Уянга-Жаргалант | 489 | 250 | 2 | 2025.05.19-05.20 |
| 2 | | Зүүнбаян-Улаан | 327 | 150 | 1 | 2025.05.21 |
| 3 | | Хужирт | 470 | 230 | 2 | 2025.05.22-05.23 |
| 4 | | Бат-Өлзий | 519 | 290 | 2 | 2025.05.24-05.25 |
| 5 | | Хархорин | 900 | 450 | 3 | 2025.05.26-05.28 |
| 6 | | Бүрд | 261 | 120 | 1 | 2025.05.29 |
| 7 | | Баян-Өндөр | 456 | 200 | 2 | 2025.05.30 |
| 8 | 2-р маршрут | Сант | 209 | 100 | 1 | 2025.06.07 |
| 9 | | Богд | 300 | 150 | 2 | 2025.06.08-06.09 |
| 10 | | Баруунбаян-Улаан | 123 | 100 | 1 | 2025.06.10 |
| 11 | | Нарийнтээл | 159 | 80 | 1 | 2025.06.11 |
| 12 | | Хайрхан дулаан | 116 | 80 | 1 | 2025.06.12 |
| **Нийт** | | | **4329** | 2200 | 19 | |

## ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ ХИЙХ ХУВААРЬ

| № | Сумын нэр | Ажиллах хоног | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Уянга | 1 | 2025.05.24 |
| 2 | Зүүнбаян-Улаан | 1 | 2025.05.25 |
| 3 | Хужирт | 1 | 2025.05.26 |
| 4 | Бат-Өлзий | 1 | 2025.05.27 |
| 5 | Хархорин | 1 | 2025.05.28 |
| 6 | Бүрд | 1 | 2025.05.29 |
| 7 | Баян-Өндөр | 1 | 2025.05.30 |
| 8 | Сант | 1 | 2025.05.31 |
| 9 | Богд | 1 | 2025.06.01 |
| 10 | Баруунбаян-Улаан | 1 | 2025.06.02 |
| 11 | Нарийнтээл | 1 | 2025.06.03 |
| 12 | Хайрхандулаан | 1 | 2025.06.04 |
| | | **12** | |

--oOo---